



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АКТ  
Дугаар 73

2017 оны 06 сарын 13 өдөр

Номгон

Г Төлбөр барагдуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Баянхонгор аймгийн Замын сангийн хөрөнгийн 2016 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга, хэмжээний хуваарилалт, зарцуулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Замын сангаар хэрэгжүүлсэн арга хэмжээний төсөвт батлагдсан захиалагчийн хяналтын зардал, ТЭЗҮ болон зураг төсвийн үнэ, магадлашгүй ажлын зардлаас Эс Эм Жи ХХК-д 371.3 мянга, Хот тохижилт ОНӨҮГ-т 138,6 мянга, Их Богд ХХК-д 1304.7 мянга, Нүнжигт инженеринг ХХК-д 372,0 мянга, Загийн орд ХХК-д 16.8 мянга, нийт 2203.4 мянган төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлээгүй, санхүүжилтийн хамт илүү олгосон байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.19-т “Захиалагч барилгын ажлын зардал, ТЭЗҮ, зураг төслийн үнэ, техник хяналтын зардал, нормчлолын сангийн зардлыг тус тусын дансанд холбогдох баримт материалыг үндэслэн шилжүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь “Улсад болон байгууллагад хохирол учруулсан” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**


2517021


Нэг. Илүү олгосон 2203.4 мянган төгрөгийг хавсралтад заасан компаниудаар 2017 оны 07 дугаар сарын 20-ны дотор төлүүлэн, Санхүү, төрийн сангийн хэлтсийн төрийн сан банк дахь Бусад татвар хураамжийн 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

Хоёр. Төлбөрийн актыг барагдуулсан баримтыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2017 оны 7 дугаар сарын 20-ны дотор ирүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга С.Байгалмаа, ерөнхий нягтлан бодогч Ц.Самбууням нарт хариуцуулав.

Дээрх төлбөрийг барагдуулаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэсэн заалтын дагуу шийдвэрлүүлэх болно.

#### АКТ

ТОГТООСОН:  
АУДИТОР  Б.АЗБАЯР  
ШИНЖЭЭЧ  Б.ЦЭРЭНЧИМЭД  
6417143544  
B-040067 9007423

ЗӨВШӨӨРСӨН:  
САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА  
С.БАЙГАЛМАА  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ  
 Ц.САМБУУНЯМ

1. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

93 .....актын хавсралт

д.д	Байгууллагын нэр	Гүйцэтгэгч компани	Илүү шилжүүлсэн мөнгө
1	Эрдэнэмандал ахлах сургуулийн гаднах авто зогсоол	Эс Жи Эм ХХК	371,356
2	Автогрейдрээр шуудуу сэргээж зам талбай тэгшлэх	"Хот тохижилт" ОНӨҮГ	138,620
3	Төв захын арын замын өргөтгөл, зогсоол	Их Богд ХХК	710,659
4	Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын засвар, автобусны 2 зогсоол хийх	Их Богд ХХК	594,024
5	Хандиваар баригдах цэцэрлэгийн гаднах авто зогсоол	Нүнжигт инженеринг ХХК	371,966
6	Загийн голын модон гүүр	Загийн Орд ХХК	16,821
	Дүн		2,203,446